



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 01 сарын 24-ны  
өдрийн 7089 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 648

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.7, 6.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ыг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар, “Мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд Хороонд бүртгүүлэх тухай журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120, 2021 оны 152 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛЭХ, АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ХОРООНД БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ**

- 1.1. Энэ журмаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Зуучлалын байгууллагад хууль зүйн зөвлөгөө үзүүлэх (цаашид “хуулийн зөвлөгөө үзүүлэгч” гэх), аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд (“аудитын үйлчилгээ үзүүлэгч” гэх) нь энэ журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж, Хороонд бүртгүүлсний үндсэн дээр зөвлөгөө, үйлчилгээ үзүүлнэ.
- 1.3. Хуулийн зөвлөгөө үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:
- 1.3.1. Энэ төрлийн үйл ажиллагааг 1-ээс дээш жил эрхэлсэн байх;
  - 1.3.2. Хоёр ба түүнээс дээш хуульчтай байх бөгөөд хуульчид нь 6 сараас дээш хугацаанд ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн үндсэн ажилтан байх;
  - 1.3.3. Хуульчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх.
- 1.4. Дээрх шаардлагыг хангасан хуулийн зөвлөгөө үзүүлэгч нь энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргах бөгөөд дээрх шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.
- 1.5. Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.
- 1.6. Энэ журмын 1.5-д заасан шаардлагыг хангасан аудитын үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргах бөгөөд дээрх шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.
- 1.7. Энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй хуулийн этгээдийг Хороо бүртгэхээс татгалзаж, хүсэлт гаргагчид албан бичгээр хариу мэдэгдэнэ.
- 1.8. Зуучлалын байгууллагад зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэгчийг дараах тохиолдолд Хорооны бүртгэлээс хасна.
- 1.8.1. зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр;
  - 1.8.2. энэ журмын 1.3, 1.5-д заасан шаардлагуудыг хангахгүй болсон;
  - 1.8.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
  - 1.8.4. Хороонд бүртгүүлснээс хойш 3 жилийн хугацаанд аливаа зуучлалын байгууллагад үйлчилгээ үзүүлээгүй;
  - 1.8.5. хяналт шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;
  - 1.8.6. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.
- 1.9. Зуучлалын байгууллагад зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын 1.7-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан тохиолдолд 1 жилийн хугацаанд Хороонд дахин хандах эрхгүй.

“Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд  
хороонд бүртгүүлэх тухай журам”-ын нэгдүгээр хавсралт

**ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТ  
ГАРГАХАД ХАВСАРГАХ МАЯГТ**

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IV байр Бага тойруу -3 Улаанбаатар -15160

Монгол улс.

Хэнээс: .....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....

(Хуулийн зөвлөгөө үзүүлэгчийн нэр ХК, ХХК, ЗБН, ББН, ХХН)

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Бүртгэлийн дугаар/ регистрийн дугаар	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь

Байгууллагын гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь (гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд) дараах хүмүүс болно. Үүнд:

№	Овог, нэр	Албан тушаал	Бүртгэлийн дугаар	Мэргэжил

Хуулийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий дараах хүмүүс болно. Үүнд:

№	Овог, нэр	Албан тушаал	Бүртгэлийн дугаар	Мэргэжил	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд хуулийн зөвлөгөө өгөх эрх хүссэн Хороонд бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын зах зээлд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө өгөх этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

/...../

/...../

/гарын үсэг/

/овог, нэр /

/...../

/ албан тушаал /

/тамга тэмдэг/

“Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд хороонд бүртгүүлэх тухай журам”-ын хоёрдугаар хавсралт

АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТ  
ГАРГАХАД ХАВСАРГАХ МАЯГТ

Огноо: .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3 Улаанбаатар -15160 Монгол улс.

Хэнээс: .....  
.....  
.....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч иргэд, хуулийн этгээд нь дараах мэдээллийг үнэн зөв бичнэ үү. Үүнд:

№	Овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь (гүйцэтгэх захирал, нэгжгийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд) дараах хүмүүс болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн байгаа ажил эрхэлж	Регистрийн дугаар	Аудитын байгууллагад эрхлэх албан тушаал

Аудитын үйлчилгээ үзүүлэх аудиторууд нь дараах хүмүүс болно. Үүнд:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад аудит хийх эрх хүссэн Хороонд бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

/...../

/албан тушаал/

/тамга тэмдэг/